

МОНГОЛ ХЭЛНИЙ ӨВӨРМӨЦ ХЭЛЦИЙН УТГАЗҮЙН АСУУДАЛД

Ц.Сүхбаатар, доктор, МУБИС

Аннотация: Идиома есть самостоятельное творчество словесного искусства, как загадка. Во-первых, она имеет образ, у которого есть объективный и субъективный стороны. Во-вторых, образ идиомы содержит в себе общие, распространённые, отдельные и определённые отношения. В-третьих, её специфическая особенность изображается законом её создания и результатом самих причинно-следственных связей её возникновения. Семантическая классификация идиом по их художественному методу является наиболее продуктивным методом тщательного рассмотрения семантических вопросов.

Түлхүүр үг: Дүр, объектив тал, субъектив тал, хэв загвар, диалектик харьцаа, энгийн хэллэг, дүрслэг хэллэг, утгазүйн ангилал

Монголчуудын аж байдал, соёл, ёс заншил, сэтгэлгээний онцлогийг тодорхой тусгадаг зүйлийн нэг бол өвөрмөц хэллэг, зүйр цэцэн үг юм. Монгол хэлний өвөрмөц хэллэг, зүйр цэцэн үгийг утгаар нь зүйлчлэн ангилах асуудал ч тулгамдаж байна. Ер нь энэ чиглэлийн судалгаа нь монгол хэлний утга зүйн судалгааны нэг бүрэлдэхүүн болно. Монгол хэлний өвөрмөц хэлцийн утга зүйн асуудлыг нарийвчлан шинжлэхийн тулд чухам ямар уг сурвалж, утга учиртай болохыг юуны өмнө байцааж эх үүдэл, учир шалтгааны тал юу байгааг ч авч үзэх шаардлагатай /Д.Бадамдорж.2001/ хэмээсэн эрдэмтэн судлаачдын үнэ цэнэтэй санал дүгнэлттэй бид санал нэг байгаагаа юуны өмнө хэлэх нь зүйтэй.

Өвөрмөц хэлц бол хэлний үгийн сангийн өвөрмөц нэгж төдийгүй бие даасан бичил уран бүтээл гэж бид үзэж байна. Уран бүтээл учраас бүтэх уран сайхны аргатай, уран сайхны тодорхой дүртэй байх ёстой гэж үзсэний үндсэн дээр өвөрмөц хэллэгийг бүтэж бүрэлдсэн уран сайхны аргаар (уран сайхны арга гэдэгт бид адилтгах өвөрмөц зарчмуудын цогцыг хамааруулж байна) нь ангилах нь өвөрмөц хэллэгийн уран сайхан хийгээд утгазүйн онцлогийг нарийвчлан шинжилж, нээн илрүүлэхэд нэн оновчтой гэж үзэж байна. Яаж тойруулж байна гээд ажиглахаар адилтгаж, зүйрлэж, тойруулна, өвөрмөц хэлц адилтгал, зүйрлэлийн олон хэлбэр нь тойрууллын хэлбэрүүд болдог гэсэн үг. Өвөрмөц хэлц бичил

уран бүтээл мөн гэхийн учир: Аливаа хэлний үгийн сангийн нэгж болох үг нь өөрөө дүр байдаггүй, харин дүр бүтээхэд оролцдог хэрэглэгдэхүүн юм. Харин хэлний үгийн сангийн бүхэллэг нэгж болох өвөрмөц хэлц нь үгийг ашиглан дүр бүтээсэн байдаг болохоороо уран бүтээл юм. Дүртэй байж уран бүтээл болдог номтой. Тэгвэл өвөрмөц хэллэг дүртэй юу? Утга зохиол шинжлэлд уран дүрийг дараах гурван шинж бүтэцтэй гэж үздэг байна. Нэгд, дүр нь объектив ба субъектив талуудтай байна. Харин субъектив тал нь зохиогчийн ургуулан бодох, дүр бүтээх арга маяг буюу уран сайхны туурвилзүйн тал /2:123/ гэдэг. Жишээ нь:

“Гэрийн нохойн сүүл өөдөө” гэсэн өвөрмөц хэлц байна. Монголчууд гэрийн нохойн сүүл өөдөө байхад гадаа ирсэн айлын нохой сүүлээ хавчдагийг (айсандаа) таньж мэджээ. Энэхүү бодот утга нь дээрхи өвөрмөц хэллэгийн объектив тал нь юм. Харин үүнийг үүнтэй төстэй өөр нөхцөл байдалд тухайлбал, хүнд хамаатуулан хэлж байгаа хийсвэр нэрлэлт нь уг дүрийн субъектив тал нь юм. Гэрийнхээ гадаа байгаа нохой айх юмгүй (сүүл нь өөдөө) байдаг нь бодот амьдралын үнэн юм. Харин гэртээ байгаа хүүхэд мөн л аав, ээж, ах, эгч нарынхаа дунд эз дийлж эрэлхүү байгаад холбогдуулан хэлж буй нь хийсвэр тал нь болно. Жич, нохой сүүлээ өргөх, сүүлээ хавчих нь айсан айгаагүйг дагалдаж илэрдэг сэтгэц- физиологийн илрэл болсон шинж төлөв, дохио тэмдгээр нь өвөрмөц хэлц хүүхдийн айхгүй байхыг айгаагүй нохойд илрэх шинжээр төлөөлүүлэн адилтгасан дүр тодорч байна. Хоёрт, дүр нь нийтлэг түгээмэл ба тусгай тодорхой диалектик харьцааг агуулж байх ёстой.

Өөрөөр хэлбэл уран сайхны дүр нь нэг талаар нийтлэгийн буюу амьдралд аль олон тохиолдох түгээмэл чанар, ёс суртахуун, үзэл бодол амьдралын хэв загварын төлөөлөл мөн (2:124). Ингэж үзвэл “Гэрийн нохойн сүүл өөдөө” байдаг нь тусгай тодорхой бөгөөд энэ хэлцийн өөр олон нөхцөлд (ангидаа, хамт олон дотроо, сургууль, баг, сум, аймаг нутаг орондоо байгаа хүний тухайд) хэлэгдэж байгаа уг хэлцийн утга хөрвөх чадвар нь түгээмэл, нийтлэг тал нь болно. Тусгай, нийтлэг хоёр бие биедээ багтаж байгаа нь энэ хоёрын диалектик харьцаатайг илтгэж байгаа гэсэн үг. Гуравт, урлаг, уран зохиолын гуравдахь онцлог мөн чанар нь түүний бүтэх хууль, үүсэн

бий болох хамгийн нийтлэг зүй тогтол болох харилцан тусгалцах нарийн төвөгтэй тогтолцоо юм. Уран сайхны дүр нь дүрслэн илэрхийлж буй зүйлтэйгээ их бага ямар нэг хэмжээгээр харьцаа холбоо, бүтээлч тусгалцаатай байх ёстой (2 :125) “Гэрийн нохойн сүүл өөдөө “байх” гэртээ байгаа хүүхдийн зовхи нь өөдөө” байх хоёр нь “өөрийн дассан орчиндоо санаа өөдрөг байдаг” гэсэн хамгийн нийтлэг зүй тогтлыг харилцан тусгаж байна.

Өвөрмөц хэллэг дэх адилтгах, зүйрлэх арга боломжийг тодруулж, утгазүйн онцлогийг нь илрүүлбэл сонин байх буй за. Зүйрлэл нь юмны нэрийг тойруулж өөрөөр нэрлэх энгийн арга бөгөөд зонхидоо сэтгэц-танин мэдэхүйд үндэслэдэг. Жишээ нь: “Амаа мэдэхгүй даага шиг” /учир мэдэхгүй балчир, дадхалгүй/; “дөргүй бух шиг” /гөжүүд, зөрүүд/; “хөөтэй төлөг шиг” /доожоогүй, үзэмжгүй/; “уургын морь шиг” /гавшгай, шаламгай/; “морь нохой мэт зүтгэх” /үнэнч/ хэлц байна. Эдгээр хэлц нь нэгд, сэтгэц танин мэдэхүй (амаа мэдэхгүй даага ямар байдгийг дааганаас нь давтаж эдэлдэг монголчууд мэднэ, бухыг (шарыг) зөвхөн монголчууд дөрлөдөг, дөргүй бух эдэлж хэрэглэхэд ямар байдгийг монголчууд мэднэ, “хөөтэй төлөг” ямар байдгийг төлөг яахаараа хөө болдгийг монголчууд мэднэ; уургын морь адууны хойноос яаж дагадгийг монголчууд мэднэ; морь, нохой эзэндээ ямар их үнэнчийг зөвхөн монголчууд л гүйцэд мэднэ)-д суурилсан, хоёрт, нүүдэлчин соёл иргэншил, ахуй амьдралын онцлог (асуудал дааганаас нь давтан сургадаг, бухыг дөрлөж эдэлдэг, ядарч турж эцсэн төлгөө гэртээ (гаднаа) авч хоцорч тэжээдэг, морио уургаар барьдаг) туссан байна.

Мөн морийг “төр улсыг тогтооход түргэн зорчих хүрд”, “ертөнцийн ганц эр”, “өстөн дайсан лугаа байлдахад нөхрийн дээд, үлдэх дайсныг даруй түргэн гүйцэгч, үл алдагч, хавт баатруудын жигүүр, өсөх залуусын биеийн чимэг”, нохойг “Мөлжүүргүй яс, шимгүй угаадсаар амин тэжээл болговч хайрлан тэтгэгч эзнийхээ төлөө чин журмаар зүтгэж, буян хөрөнгийн манаанд буцалтгүй сэтгэлийг шүтэн нэгэн насыг барагч” гэж эрхэмлэдэг монголчуудын сүлд оюуны дээд үнэлэмж шингэсэн байна. Ертөнцийн ганц эр. Тэр юу вэ? гэсэн оньсогод морины дээд зэргийн үнэлэмж илэрдэг. Энэ оньсогыг “сүлд оюуныхаа дээд эрэмбэд “морь” гэж гайхамшигтай тайлсан “/С.Э/ гэж судлаачид үздэг. Үүнтэй санал нэгдэхийн сацуу нэг зүйлийг нэмж хэлэхэд илүүдэхгүй болов уу гэж санана. Энэ оньсого бүтцийн хувьд дүрслэлгүй (необразный) боловч

оюунлаг (интеллектуальный) шинжтэй байгаа юм. Тэгээд ч энэ оньсого нь эр хүйстэн хүн, амьтнаас гагц эр унага л /морь/ мээмгүй төрдөгт үндэслэсэн сэтгэц- танин мэдэхүйн суурьтай гэж бид үзэж байгаа юм. Гуравт, найруулгын өнгө аясаараа өмнөх хэлцүүдийн эхний дөрөв нь үл ойшоосон, сөрөг үнэлэмж, шоглосон аястай байгаа бол “морь нохой мэт зүтгэх “нь эрхэмсэг, бахархалт өнгө аястай байна. Сэтгэц-танин мэдэхүйн үндэслэлээ жишиг хэмжүүр болгодог нь зүйрлэл хэлцийн ГОЛ онцлог гэж болохоор байдаг. Аливаа юм үзэгдлийг адил төсөөгөөр нь жишдэггүй, харин хоорондоо ямар ч төсөөгүй зүйлсийг гадаад дотоод аль нэг шалтгаант холбоо, харилцан шүтэлцээгээр нь хамааруулж, нэгийг нь нөгөөгөөр орлуулж хэлэх нэг янзын уран яруу хэрэглүүрийн аргыг төлөөлүүлэл гэнэ (Дулам, Хасбаатар, 1980, х.154).

Сэтгэц-танин мэдэхүйд үндэслэн төлөөлүүлэх аргаар бүтсэн нэгж хэлцийн өвөрмөц хэлбэрүүд бас байна. Жишээ нь: “Нүүр улайх, нүүрээ түлэх, чих халууцах” гэдэг хэлцүүд нь “ичих, зовох” гэсэн утгатай. Ичиж зовсны улмаас нүүр улайдаг нь хүний бие цогцост үүсч буй сэтгэц-физиологийн харилцан нөлөөллийн илрэл юм. Тэгэхээр энд энэхүү ичих зовох үйлийг түүнийг дагалдаж гарах сэтгэц-физиологийн илрэх байдал буюу үр дагавраар нь төлөөлүүлсэн байна. Хүний сэтгэлийн төлөв байдал нүүр, нүдэнд нь голцуу тод илэрдэг. Тийм ч учраас ихэд гайхахыг нүд нь орой дээрээ гарах гэх жишээтэй. Мөн шогшихыг “сүүл хөдөлгөх”, жонжуулахыг “зогдор хөдөлгөх” гэдэг нь тухай тухайн үйлийг дагалдан гарах шалтгаант холбооны үр дагавраар нь дүржүүлэн илэрхийлжээ. Мөн “гуяа алгадах” /баярлах/, “дал (мөр) алгадах” /найзархах, дотносож, зиндаархах/, “толгойгоо (тархиа) шаах” /харамсах/, “нударга зангидах” /занах, зүхэх/, “шүд зуух” /тэсвэрлэх, тэвчих, занах/, “цээжээ дэлдэх” /бардамнах, сагсуурах, омогших/, “амаа барих” /харуусах/, “зовхи нь буух” /дургүйцэх, урамгүй болох/ “ гэсэн хэлцүүд нь бүгд сэтгэлийн хөдөлгөөн, төлөв байдлыг тэдгээрийг дагалдан үүсдэг дохио зангаа, шинж тэмдэг, үйлдэл хөдөлгөөнөөр нь төлөөлүүлж нэрлэсэн байна. “Хүний алга өөд нь харуулж үзээгүй” /харамч/, “гар сунгах” /туслах/, “гар татах” /харамлах/, “хошуу цорвойх” /гуйх/, “хошуу дэвсэх” /гуйх/ гэсэн хэлц нь харамлах, өгөх, гуйх зэрэг үйлийг дагалдаж гардаг хөдөлгөөн, нүүр царайны хувирлаар төлөөлүүлсэн байна. Эдгээр хэлцийн утгыг тайлахдаа ч бодот ба хийсвэр нэрлэлт хоёрын харьцааны тохирох уулзварыг үгийн утгыг бүрдүүлэгч утганцрын тохироонд бус бодот нэрлэлт /харамлах/-ийн үед үүсдэг /өгөхгүй

бол алгаа тосдоггүй/ хөдөлгөөн нь нүүр амны хувиралд тулгуурласан байна. Мөн “сархинаг хатах” /ихэд цангах/ гэсэн хэлц бий. “Сархинаг” хивдэг амьтны дөрвөн хэлтэст ходоодны нэг бөгөөд хоёрдох удаагаа боловсорсон идэш хоол түүнд орно. Хонь, ямаа, үхэр, тэмээ сархинагтай. Эдгээр мал усаар их гачигдахаар сархинагных нь баас хатсан байдгийг мал төхөөрөөд гэдэс дотрыг нь цэвэрлэж, сархинагийг нь хүртэл иддэг монгол хүн мэднэ. Энд монголчуудын сэтгэц- танин мэдэхүйн онцлог нь хэлцийн чухамхүү үүдэл санаа болжээ. Яагаад гэвэл хүн сархинаггүй байтал хивэгч амьтны физиологийн процессийг хийсвэрлэж хүнд нялзаан тохож шог аястай болгожээ. Энд үйлийн шалтгааныг үр дагавраар нь төлөөлүүлсэн байна. Энэ хэлцийн бодот ба хийсвэр нэрлэлт нь “усаар дутах, усгүй болох” гэсэн утганцраараа холбогдож байна. “Шон босгоогүй бол шаазгай хаанаас суух” гэдэг шиг усаар дутаагүй бол сархинаг хаанаас хатах вэ, шогшуулаагүй бол сүүл хаанаас хөдлөх вэ, жонжуулаагүй бол зогдор хаанаас хөдлөх билээ.

Ер нь үйлийг шалтгаанаар нь төлөөлүүлж үүсгэсэн хэлц олонтаа тохиолдож байна. Тухайлбал, “чихэнд хүрэх”, “чих дэлсэх”, “чих цохих”, /сонстох, дуулдах/ гэсэн утгатай хэлц байна. Энэ нь үйлийг эрхшээгчээр нь төлөөлүүлсэн хэрэг юм. Сонсохыг чихээр, үгийг амаар, үзэхийг нүдээр, ухааныг тархи толгойгоор, сэтгэлийг зүрхээр, ураг садныг элгээр, явахыг хөлөөр гэх мэтээр төлөөлүүлэх нь элбэг байна. Бас үйлийг үр дагавраар нь төлөөлүүлэн эерүүлж хэлнэ. Тухайлбал хүүхэд өвчилж өвдөхийг “хүүхэд айлгах” гэх жишээтэй. Юм, үзэгдлийн дэс дарааг амьтны үе гишүүний дарааллаар төлөөлүүлдэг. Жишээ нь: “Түрүү морь”, “аман хүзүүний морь” гэсэн хэлц бий. “Түрүү” нь “толгой түрүү”-ний “түрүү” буюу эхэнд толгойд ирсэн морь болно. Нэгд давхисан морь бол амьтны эрхтэн, үе гишүүний дарааллаар төлөөлүүлэхээр түрүү (буюу толгой) морь болно. Хоёрт давхисан морийг аман хүзүүний морь (буюу аман хүзүүдлээ) гэнэ. Аман хүзүү гэдэг нь толгойны ястай залгадаг, хүзүүний I үе учраас хоёрдахийг төлөөлөх бөгөөд заамал зургаан хүзүүний эхнийх учраас аман хүзүү нэрийг авсан хэрэг. Ингээд аман хүзүүний морь бол хоёрдахь морь болно. Уралдааны эхэнд ирсэн морь түрүү морь юм чинь адагт ирсэн морь сүүл (буюу сүүлдсэн) морь болно. “Айргийн тав” гэж эхний тавд давхисан морийг хэлдэг нь эхний таван морийг онцгойлон үзэж, цоллож (цол, чимэг өгч), айргаар магнай зоог нь мялаадаг ёс уламжлалаас үүссэн хэлц юм. Чингэж амьтны

үе гишүүний байрлалаар төлөөлүүлэн нэрлэх нь зөвхөн хурдны морьтой холбогдохоор барахгүй ер юмс үзэгдлийн эх адгийг төлөөлдөг байна. Тухайлбал: “Хөл толгойгоо алдах” (эх адгаа алдах), “үхрийн сүүлэн дээр хутгаа” /ажил үйлс дуусгахын (төгсгөхийн) даваан дээр/ гэх мэтээр харагдана. Ер нь өвөрмөц хэлц төдийгүй, үгийн олон салаа утга онцлог сэтгэлгээний үр дүнд үүсдэг байна. Товчхон жишээлэхэд: “амдах” (урдаас тосох), “сүүлдэх” (адагт ирэх) хоёр нь ам, сүүлний байрлалаар төлөөлүүлж хэлсэн болох нь лавтай. Үүссэн даруйдаа сонин содон дүр дүрслэлтэй байснаа яваандаа тэр нь бүдгэрч одоо бидний үед ердийн, найруулга дундын үг болсон байна. Үүнээс үзвэл хийсвэрлэн сэтгэж, аналогийг үүсгэж нэрлэх нь хэлний үгийн санг баяжуулах чухал арга хэрэглүүр болдог гэж дүгнэж болно. Хийсвэрлэн сэтгэж аналогийг үүсгэсэн нэрлэлт нь юмс, үзэгдэл, хөдөлгөөнийг нуршихгүй товч тодорхой, уран яруу илэрхийлдгийг өвөрмөц хэлц болгоноос, юмс үзэгдлийн хийсвэр нэрлэлтээс харж болно. Энэ бол өвөрмөц хэлцийн утга, үүрэг найруулгын суурь шинж мөн.

Өвөрмөц хэлцэд цаг хугацааны нэрлэлтийг хүндийн хэмжүүрийн нэрлэлтээр илэрхийлдэг байна. Жишээ нь: “хөнгөн хөлтэй, хүнд хөлтэй” гэсэн хэллэг байдаг. Энэ нь хөлийн хүнд хөнгөнийг хэлээгүй удаан түргэнийг хэлж байгаа нь ойлгомжтой. Бас “хөнгөн ажил, хүнд ажил, хөнгөн бодлого, хүнд бодлого” гэсэн ердийн холбоо үгэнд орсон “хүнд, хөнгөн” гэсэн үгс жин банг хэлээгүй “амар, хялбар”, “бэрх, хэцүү”-г хэлж байгаа нь ойлгомжтой. Мөн “хүнд гартай”, “хөнгөн гартай” гэх нь “өвтгөхгүй” гэсэн утгатай байна. “Хөнгөн хүн” гэвэл ул суурьгүй, бодлогогүй, “хүнд хүн” гэвэл буйртай, бодлоготой гэсэн утгатайг хүн болгон мэднэ. Миний мэдээжийн юмыг нуршсаны учир юу вэ? гэвэл өвөрмөц хэлцийн уг үүдэл учир шалтгааныг тодруулах гэсэн юм. Дээрх жишээнээс үзвэл хөнгөн гэдэг бодот нэрлэлтийг хийсвэрлээд түргэн (1), өвтгөдөггүй (2), амархан (3), суурьгүй (4) гэсэн дөрвөн утгаар нэрлэжээ. “Хүнд” гэдгийг удаан (1), өвтгөдөг (2), хэцүү (3), буурьтай (4) гэсэн утгаар хэрэглэсэн байна. Энд бодот нэрлэлтийг хийсвэр нэрлэлт болгохдоо бидний өмнө ярьсан адил төс мэдлэг учир шалтгааны дотоод холбоо зэрэгт үндэслээгүй байна. Харин хүний санаа сэтгэлд “түргэн” нь хөнгөн юм шиг сэтгэгдэл төсөөлөл төрүүлснээс үүдсэн сэтгэц-сэтгэлгээний онцлогт үндэслэсэн байна. Өвөрмөц хэлцийн бүрэлдүүлбэрүүд нь үгийн сангийн утгаа бүр мөсөн алдаж утга шилждэг гэдэгтэй бид санал нийлэхгүй байгаа. Жишээ нь: “Хөнгөн

хөлтэй” (морь)- явдал түргэнтэй мөн юм бол, “хөл хүнд” (морь)- хашин морь мөн юм бол юу нь утга шилжээд байна. Утга шилжсэн юм бол энэ хоёр нэрлэлтийн утга чанар тэнцүү байж чадахуу? Чадахгүй. “Сархинаг хатах”- ихэд цангах хоёр утга чанар нэг өвөрмөц хэлц утга шилжээгүй учраас л бие биеэ орлож байгаа юм. “Сархинаг хатах дөхлөө” гэвэл хөөрхий минь их цангажээ гэж ойлгоно. “Ам их цангалаа” гэвэл “хөөрхий минь сархинаг нь хатах шахжээ” гэж ойлголцож байгаа нь утга шилжээгүйг харуулж байна гэсэн үг юм. Утга шилжээгүй юм бол тэгээд яаж байгаа юм бэ? гэсэн асуулт гарна. Хариу нь: нэг юмыг хоёр өөрөөр нэрлэж байгаа юм. Ихэд цангах нь бодот нэрлэлт референт, сархинаг хатах нь цангах үйлийг үр дагавраар төлөөлүүлсэн хийсвэр нэрлэлт (денотат) юм.

Энгийн хэллэг, дүрслэлт хэллэг хоёр хоорондоо элэг ургийн холбоотой, алаг бөөрийн сүлбээтэй байдаг, хэзээ ч утгаа бүрмөсөн алдаж өөрчлөгддөггүй. Утгаараа бүрэн тохирохгүй ч тэрхүү утгыг бүрдүүлэгч олон утганцрын аль нэгээр холбоотой байдаг. Жишээ нь сархинаг хатах- их цангах хоёр нь усаар дутах, усгүй болох гэсэн утганцраараа ургийн холбоогоо хадгалж яваа юм.

ДҮГНЭЛТ

- Монгол хэлний өвөрмөц хэлц бол үгийн урлагийн бичил уран бүтээл мөн.
- Тийм учраас өвөрмөц хэлцийн талаар тогтолцоотой мэдлэг бүтээхийн тулд тэдгээрийг үүдэж бүрэлдсэн уран сайхных нь аргаар ангилах нь өвөрмөц хэлцийн утгазүйн судлалд хамгийн үр дүнтэй арга болно.
- Үгийн утга бүрэн шилждэггүй, утгын холбоогоо аль нэг утганцраараа хадгалж байдаг.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Бадамдорж, Д. (2001). *Монгол хэлний утга судлал*. Улаанбаатар
- Энхбаяр, С. (2011). Уран сайхны арга болон уран дүрийн амин сүнс нь адилтгал болох нь. *Монгол судлалын чуулган*. №11/46/ Улаанбаатар